

## ТАНИЛЦУУЛГА

*Дүрэм батлах Засгийн газрын  
тогтоолын төсөл боловсруулсан  
тухай*

Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын байгууллагын болон энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална” гэж, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “.... Нийгмийн даатгалын байцаагчийн дүрмийг Засгийн газар батална” гэж тус тус заасан.

Дээрх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм, хоёрдугаар хавсралтаар “Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм”-ийг батлан, мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 37 дугаар зүйлийн 37.15 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрмийг Засгийн газар батална” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Дүрэм батлах тухай” Засгийн газрын тогтоолын болон дүрмийн төслийг боловсрууллаа.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 1 480 байцаагч, ажилтан ажиллаж байгаа бөгөөд 576 нь улсын байцаагчийн, 37 нь улсын ахлах байцаагчийн эрхтэй байна.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар нийгмийн даатгалын байгууллага болон улсын ахлах байцаагчийн үйл ажиллагаа, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, байцаагчийн эрх, үүрэг, хориглох зүйл гэх зэрэг харилцааг зохицуулах юм.

Засгийн газрын тогтоол батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ